



ASA 30/003/2012

МОНГОЛ УЛС: 2012-2015 ОНД АЖИЛЛАХ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

Эмнести Интернэшнл байгууллагаас Улсын Их Хурлын (парламентын) гишүүдийг сонгуульт хугацаандаа Монгол Улсын хүний эрхийн үндэсний үзүүлэлтийг сайжруулах, Монгол Улс нь өөрийн орноор хязгаарлахгүй хүний эрхийг дээдлэн, хамгаалах явдлыг тууштай сахигч болохоо нотлон харуулахыг уриалж байна.

Өмнөх Засгийн газар 159 дүгээр тогтоолоороо 2010 онд гаргасан Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын тухай НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгийн зөвлөмж, Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны зөвлөмж, 2011 онд гаргасан Хүний Эрхийн Хорооны зөвлөмж болон НҮБ-ын гэрээний байгууллагуудаас сүүлийн жилүүдэд гаргасан зөвлөмжийг тусгасан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө баталсныг Эмнести Интернэшнл байгууллага онцлон тэмдэглэж байна.

Доорхи санал нь одоо хэрэгжүүлж буй Ерөнхий Төлөвлөгөө болон НҮБ-ын гэрээний байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжид тусгасан хүсэл эрмэлзлүүдийг дахин тодотгох, түүнд нийцүүлэх зорилготой. Эмнести Интернэшнл байгууллагаас Улсын Их Хурлын гишүүдийг доор дурьдсан Хүний эрхийн хэлэлцэх асуудлын заалтуудыг Монгол Улсад хүний эрхийг дээдлэн, хамгаалах ажлынхаа нэг хэсэг болгон хэрэгжүүлэхийг уриалж байна.

Цаазаар авах ялыг хуулиасаа хасах

Монгол Улс энэ оны нэгдүгээр сард Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай нэмэлт II протоколд нэгдэн орсон билээ. Энэ алхмаа баталгаажуулахын тулд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж цаазаар авах ялыг ялын төрлөөс хасах ёстой. Эмнести Интернэшнл байгууллага нь Монгол Улс Эрүүгийн хуульдаа хэд хэдэн асуудлаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд Эрүүгийн хуульд оруулах бусад өөрчлөлтийн тухай саналыг энэхүү баримт бичигт бүрэн тусгасан болно.

- Эрүүгийн хуульд байгаа цаазаар авах ялыг ялын төрлөөс хасах;
- Монгол Улсад цаазын ялыг гүйцэтгэж байгаа тухай мэдээллийг цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүл болон олон нийтэд нээлттэй байлгахын тулд цаазаар авах ялыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомжуудаас хасах;

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцах, ял завших явдалтай тэмцэх

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцах, ял шийтгэл завших асуудлыг шийдэх хуулийн заалт дутагдалтай байгаад санаа зовниж буйгаа Эмнести Интернэшнл байгууллага өмнө нь илэрхийлж байсан. Тухайлбал, Монгол Улсын Эрүүгийн хуульд байгаа эрүүдэн шүүх гэмт хэргийн тодорхойлолт НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид заасантай бүрэн нийцээгүй. Түүнчлэн, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 44.1 дүгээр зүйлд заавал биелүүлэх ёстой тушаал захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг, сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй гэж заасан байдаг. Энэ нь хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудыг, тухайлбал цагдаагийн алба хаагч хүний амь хороох буюу эрүүдэн шүүх тохиолдолд ял завшуулж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, түүний дотор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийг зөрчиж байна.

Хорих газруудад байцаалт явуулах үеэр хоригдогсдыг эрүүдэн шүүдэг, бусад хэлбэрээр хэрцгий ханддаг хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудыг ял завшуулах явдал Монгол Улсад өргөн тархсан. Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудын эсрэг гаргасан санал гомдлыг шүүхээр шийдүүлэх нь ховор бөгөөд цөөхөн хэрэгт л ял шийтгэл хүлээсэн байдаг. Урьдчилан хорих газрууд, түүний дотор 2011 онд шинэ байгууламжинд орсон 461 дүгээр хорих анги нь байцаалт авах өрөөнүүдэд дүрс бичлэгийн камер байрлуулсан хэдий ч энэ тоног төхөөрөмжийг хянах, буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх журам байхгүй бөгөөд хараа хамгаалалт хангалтгүй байна.

Эмнести Интернэшнл нь Монгол Улсыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо болон НҮБ-ын Тусгай илтгэгчийн гаргасан санал зөвлөмжүүдийг бүрэн биелүүлж, түүний дотор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт Протоколыг (ЭШЭКНП) соёрхон батлах шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэж байна. Нэмэлт Протокол нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцах явдлаас үндэсний болон олон улсын түвшинд урьдчилан сэргийлэх мэргэжлийн, хараат бус механизмууд бий болгох, хорих газарт очиж шалгалт хийх нөхцлийг бүрдүүлдэг. Монгол Улс одоогоор ЭШЭКНП-ыг соёрхон батлаагүй байгаа бөгөөд хорих газруудад хүний эрх зөрчигдөж буй эсэхэд бие даасан, хараат бус шалгалт хийх албан ёсны тогтолцоо бүрдээгүй байна.

- Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж эрүүдэн шүүхийн тодорхойлолтыг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид заасантай бүрэн дүүрэн нийцүүлэх;
- Хүний эрх зөрчсөн этгээд ял шийтгэлгүй үлдэх боломж олгохгүйн тулд 44.1 дүгээр зүйлийг хасах, эсвэл өөрчлөн найруулах;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах;
- Одоо хэрэгжиж буй хууль тогтоомж, ялангуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах асуудлаар иргэний нийгэм болон Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисстой хамтран ажиллаж, Нэмэлт Протоколын заалтад нийцсэн Үндэсний Урьдчилан Сэргийлэх Байгууллага байгуулах;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцаж шийтгэх явдал, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар мэргэжилтнүүдийн гаргасан зөвлөмж, түүний дотор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн болон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх алхмуудыг нэн даруй хийх;

Монгол Улсаас Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын Дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай хууль тогтоомж батлах

Монгол Улс 2002 онд соёрхон баталсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж байгааг баталгаажуулсан нөхцөлүүд Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдаагүй байгааг Эмнести Интернэшнл тэмдэглэж байсан. Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулах асуудлыг бүрэн дэмжиж, Ромын дүрэмд нэгдэн орсон эхний 60 орны нэг болох Монгол Улс Олон Улсын Эрүүгийн Шүүхтэй хамтран ажиллах гэрээний үүргээ хараахан биелүүлээгүй байна¹. Олон Улсын Эрүүгийн Шүүхээр эрэн сурвалжлагдаж буй олон улсын шударга шүүхээс оргон зайлсан этгээдүүдийг хамгаалан орогнуулсан орон болохгүйн тулд Монгол Улс хамтран ажиллах үүргээ нэн тэргүүнд биелүүлэх ёстой.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж:

- Төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг, дайны гэмт хэргүүд, эрүүдэн шүүх, шүүхээс гадуур цаазлах болон хүчээр сураггүй болгох хэрэгт хамаарах нутаг дэвсгэрийн хүрээг тодорхойлж, эдгээр гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн шүүн таслах харьяаллыг Монгол улсын шүүх хэрэгжүүлэх эрхийг хангаж өгөх;

Энэ бүлэгт дурьдсан зөвлөмжүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг "Монгол Улс: Монгол Улсын Эрүүгийн хуулийн төсөлд оруулах санал, зөвлөмжүүд" (Эмнести Интернэшнл, 2009 он, ASA 30/001/2009) баримтаас үзнэ үү: <http://www.amnesty.org/en/library/info/ASA30/001/2009/en>

- Холбогдох байгууллагууд олон улсын эрх зүйн дагуух бүх төрлийн гэмт хэргүүд, ялангуяа төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг, дайны гэмт хэргүүд, эрүүдэн шүүх, шүүхээс гадуур цаазлах болон хүчээр сураггүй болгох зэрэг хэргүүдийг мөрдөн байцаах, шийтгэх боломжтой байхыг баталгаажуулах;
- Өндөр албан тушаал, эрх мэдэл бүхий этгээдийг Ромын дүрмийн дагуу эрүүгийн хэрэгт татах тусгай заалтуудыг нэмэх;
- Захирагчийн тушаал нь төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг, дайны гэмт хэргүүд, эрүүдэн шүүх, шүүхээс гадуур цаазлах болон хүчээр сураггүй болгох гэмт хэргүүдэд хэзээ ч хамгаалалт болж чадахгүйг тогтоож өгөх;
- Төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг, дайны гэмт хэргүүд, эрүүдэн шүүх, шүүхээс гадуур цаазлах болон хүчээр сураггүй болгох гэмт хэргүүдэд хязгаарлалт тогтоосон нөхцлийг хасах;

Ялгаварлан гадуурхалттай тэмцэх

Монгол Улсад цөөнх болон нийгмийн тодорхой бүлгүүдийг ялгаварлан гадуурхдаг тухай мэдээлэл Эмнести Интернэшнл байгууллагад ирдэг. Ялгаварлан гадуурхалт оршин тогтносоор байгаа нь хувь хүмүүс хүний эрхийн бусад зөрчилд өртөх эрсдлийг бий болгож, тэдний эсрэг дайралт, халдлагууд мэдээлэгдэхгүй байх, гэмт этгээд шийтгэгдэхгүй өнгөрөх байдлыг үүсгэдэг. Ял шийтгэлгүй үлдэхийн эсрэг хуулийн бүрэн төгс хамгаалалтгүй, эрх мэдэлтнүүд дорвитой арга хэмжээ авахгүй байх нь энэ байдлыг улам өөгшүүлж, хурцатгадаг. Хүмүүсийг ялангуяа хүйсийн баримжаа илэрхийлэл болон/эсвэл бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах, дайсагнах, алагчлах явдал сэтгэл зовниулсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор бие махбодь, оюун санаа, оюун ухаан, мэдрэхүй мэдрэмжийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийг сайжруулах, бодлого ба түүний хэрэгжилтийг бэхжүүлэх шаардлагатай байна.

- Ялгаварлан гадуурхалттай тэмцэж, түүний дотор ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэг үзэл, арьсны өнгө буюу шашин шүтлэг дээр үндэслэсэн аливаа үйл ажиллагааг хориглосон хууль тогтоомжуудыг шинээр гаргах. Хууль тогтоомж нь ялгаварлан гадуурхалт гэдгийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад тодорхойлсонтой нийцүүлж, лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хувь хүмүүм, ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс, мөн ялгаварлан гадуурхалтад ихээр өртдөг Монгол Улсын иргэн бус хүмүүсийн эрх хамгаалагдсан байхыг баталгаажуулж өгөх ёстой.
- Бие махбодь, оюун санаа, оюун ухаан, мэдрэхүй мэдрэмжийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулан одоо хэрэгжиж буй хууль тогтоомжуудыг бэхжүүлэх;

Газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговрын тухай хуулиуд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцсэн байдлыг хангах

Улсын Их Хурлаар Газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговрын тухай болон Хот төлөвлөлтийн тухай шинэ хуулиудыг хэлэлцэн, батална. Эдгээр хууль нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн тухай гэрээ хэлэлцээр, түүний дотор Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактаг нийцэж байх ёстой.

- Газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговрын тухай болон Хот төлөвлөлтийн тухай хууль тогтоомжууд нь:
 - Албадан нүүлгэхийг хориглож, аливаа байдлаар нүүлгэхийн өмнө заавал дагаж мөрдөх хамгаалалтын арга хэмжээг авах. Эдгээр хууль нь Хөгжилд суурилсан нүүлгэн шилжүүлэлт ба шилжин суурьшилтын талаарх НҮБ-ын удирдамж, үндсэн зарчмуудад тулгуурласан байх ёстой бөгөөд олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байх;
 - Хүн бүр тэднийг албадан нүүлгэх, айлгах, бусад байдлаар сүрдүүлэхээс хамгаалагдсан эзэмшигчийн баталгаат байдлын наад захын төвшингөөр хангагдсан байхыг баталгаажуулах;
 - Эзэмшигчийн баталгаат байдлыг нэмэгдүүлж, бололцоотой тохиолдолд тэдний нөхцөл байдлыг тогтворжуулахад саад учруулж буй одоогийн төлөвлөлт болон бусад дүрэм журмыг хянах хүрээг тогтоож өгөх;

- Хүний амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулах аюултай болон/эсвэл бохир орчинд нүүлгэн суурьшуулахыг шууд хориглож, нүүлгэн суурьшуулах бүх газар нь зохистой орон байраар хангагдах эрхийн асуудлаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн байхыг баталгаажуулахыг эрх бүхий хүмүүст үүрэг болгох;
- Ямар ч хүн төлбөрийн чадвараасаа үл хамааран цэвэр ус, эрүүл ахуйн наад захын шаардлага хангасан үйлчилгээ хүртэх;
- Хүн бүр ялгаварлан гадуурхагдахгүйгээр орон байраар хангагдах тэгш эрх эдлэхийг баталгаажуулах;
- Төсөл хэрэгжүүлэх аливаа хувийн хэвшлийн оролцогчдыг зохицуулж, тэдний зүгээс суурьшуулалтанд өртөж буй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, олон улсын хүний эрхийн хуульд нийцсэн хууль тогтоомжид заасан хамгаалалтын бүх арга хэмжээг мөрдөх явдлыг баталгаажуулах;
- Эрх бүхий байгууллагад хяналт тавих механизмийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд бий болгох, эрх нь зөрчигдсөн хүмүүсийн хохирлыг нааштайгаар барагдуулах зорилгоор уг эрх бүхий газрууд нь хуулиа тогтмол мөрдөж байгааг баталгаажуулах.

Чанартай хүний эрхийн боловсролоор хангах

Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, бодитойгоор эдлүүлэхэд хүний эрхийн боловсрол хувь нэмрээ оруулдаг. Монгол Улс ард түмнийг хүний эрхийн боловсролоор хангах үүрэгтэй бөгөөд хүний эрхийн боловсролыг зөвхөн дунд, дээд боловсролын байгууллагад заах бус цагдаа, хуулийн мэргэжилтнүүд, шүүх захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг төрийн бүх албан хаагч, агентлагуудыг хүний эрхийн боловсрол, сургалтаар үргэлжлүүлэн хангах ёстой.

Түүнээс гадна, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс 2011 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын Тунхаглалаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг дэмжих зорилгоор хүн бүр боловсрол эзэмших эрхтэй гэдгийг дахин баталгаажуулсан билээ. Энэ тунхаглалаар Улс орнууд хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжих, явуулах үндсэн үүрэгтэй гэж зарласан байдаг. Нөгөөтэйгүүр, энэ Тунхаглал нь Улс орнуудын зүгээс хүний эрхийн боловсролыг тууштай дэмжиж байгаагаа харуулах гол баталгаа юм. *Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөр болон Тунхаглалыг* баталсан явдал нь багш, сурган хүмүүжүүлэгч, бодлого боловсруулагчдад үндэсний бодлого, тэргүүлэх зорилтуудаа олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэн дахин нягтлах боломжийг олгож байгаа юм.

Монгол Улс Хүний Эрхийн Зөвлөлөөс Монгол улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч, хүн бүрийн эрхийг хамгаалах, хүндэтгэх соёлыг төлөвшүүлэх зорилгоор уг Тунхаглалыг хүмүүст хүргэх, түүнийг нийтээр хүндэтгэх, ухаж ойлгох явдлыг сурталчлах үйлст хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай.

- Хүний эрхийн боловсролыг албан боловсролын тогтолцоо, түүний дотор дээд боловсролтой уялдуулж өгөх, багш, сурган хүмүүжүүлэгч, төрийн албан хаагч, хууль хяналтын байгууллагын ажилтан, цэргийн бие бүрэлдэхүүнд зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөрийн удирдамжийг багтаасан, Хүний Эрхийн Боловсрол, Сургалтын тухай НҮБ-ын Тунхаглал болон Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрт нийцсэн Хүний Эрхийн Боловсролын Үндэсний Төлөвлөгөөг нэн даруй багтах ёстой. Үүнд, уг төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах хангалттай хөрөнгийг улсын төсөвт тусгах.
- Албан, албан бус боловсрол, сургалттай холбоотой бүх хууль тогтоомж, удирдамж, тэдгээрийн бүх шатанд (үүнд: сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсрол орно) хүний эрхийн чиг хандлагыг тусгах;
- Хүний эрхийн боловсрол, сургалт нь (а) Хүний эрхийн *тухай* боловсрол буюу хүний эрхийн хэм хэмжээ, зарчим, тодорхойлох үнэт зүйлсийг бататгах, хамгаалах механизмын талаархи мэдлэг, ойлголтыг багтаасан боловсрол; (б) Хүний эрхээр дамжуулсан боловсрол буюу сургагч, суралцагч нарын эрхийг эрх тэгш хүндэтгэх замаар сургаж, заадаг онцлогтой боловсрол; (в) Хүний эрхийн *төлөө* боловсрол буюу хүмүүст өөрсдийнхөө эрхийг эдлэх, хэрэгжүүлэхийн хамт бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалах бололцоог олгох ёстой.

- Төрөөс хүний эрхийн боловсролыг Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Хууль зүй дотоод хэргийн яам, бусад холбогдох төрийн албад, агентлагийн бодлого боловсруулагчдад сурталчлах, ингэснээр дээрх эрх бүхий байгууллагуудаас багш, сурган хүмүүжүүлэгч, сургагч (албан ба албан бус боловсролын салбарын бусад ангилал), эрүүл мэндийн болон нийгмийн ажилтнууд, эмзэг болон ялгаварлан гадуурхагддаг тодорхой бүлгүүдтэй ажилладаг бусад хүнийг хүний эрхийн боловсрол, сургалтаар чанартай хангах явдлыг батлагаажуулах;
- Албан боловсролтой холбоотой хууль тогтоомжид оруулж буй аливаа нэмэлт өөрчлөлт нь хүний эрхийн соёлыг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд сурталчлах явдлыг дэмжсэн байх. Үүнд, хичээлийн болон хичээлээс гадуурх хөтөлбөр, сургуулийн засаглал, сургуулийн хамт олны гишүүдийн харилцаа болон сургуулийн орчин зэрэг бүхий л хүрээнд тэгш эрх, хүндэтгэл, ялгаварлан гадуурхалт алагчлалгүй байх, оролцоог хангах, хариуцлага хүлээх, чадавхжуулах, зэрэг хүний эрхийн зарчмуудыг хамрах ёстой.
- Төрийн байгууллагын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаархи , үүнд холбогдох олон улсын, бүс нутгийн, үндэсний эрх зүйн үндсэн тогтолцооны тухай сургалтыг тогтмол явуулдаг байхыг баталгаажуулах;